

Шинэ номын мэдээ-2016

Монгол улсын өрсөлдөх чадварын тайлан-2014



Монгол улсын өрсөлдөх чадварын тайлан. -УБ.: “Соёмбо принтинг” ХХК, 2015. -236х.

Энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь Монгол улсын эдийн засгийн давуу болон сул талыг тодорхойлж оновтой бодлого, шийдвэр гаргахад хувь нэмэрээ оруулахад оршино. Бидний үзэж байгаагаар төрийн бодлогын үндсэн зорилго нь дотоодын аж ахуйн нэгжүүд олон улсын зах зээлд гарч үйл ажиллагаа амжилттай явуулах боломжийг дэмжин бүрдүүлэх замаар улс орны хөгжил цэцэглэлтийг сайжируулахад чиглэнэ. Иймд энэхүү тайлангаар Монгол улс алсын ирээдүйд илүү хөгжил цэцэглэлтэнд хүрэхэд нөлөөлөх голлох хүчин зүйлсийг тодорхойлохыг зорьсон.

Шинжлэх ухааны судалгааны арга зүй, шинжлэх ухааны мэдээлэл

Алтангэрэл А., Батмөнх Ш.



Шинжлэх ухааны судалгааны арга зүй, шинжлэх ухааны мэдээлэл. –УБ.: 2015. -109х

Их сургуулийн оюутан магистрант, докторант нарт хандан толилуулсан зөвлөмж бүхий энэ гарын авлагад “Шинжлэх ухааны судалгааны арга зүй, шинжлэх ухааны мэдээлэл”-ийн үндсэн элементүүд, тулгуур ухагдахуун, зүй тогтолуудыг олон жил их сургуулийн бүх шатны сургалтанд чармайн зүтгэж, оюутан болон магистрийн дипломууд, докторын /Ph.D/диссертацийг удирдаж ирсэн туршлагадаа түшиглэж эмхэтгэж оруулсан болно.

Удирдлагын бүртгэл, шинжилгээ

Моломжамц Д., Дэлгэрцэцэг Ч.



Удирдлагын бүртгэл, шинжилгээ. -2 дахь хэвлэл. –УБ.: “МУИС”-н хэвлэх үйлдвэр, 2015. -286х.

Энэхүү номонд аливаа аж ахуйн нэгжийн удирдлагын өмнө тулгардаг, эдийн засгийн буюу бизнесийн шийдвэр гаргахад зайлшгүй мэдэх шаардлагатай зардлын бүтцийг шинжлэх арга зүй, зардал-үйлдвэрлэл-ашгийн хамааралыг шинжлэх арга зүй, ялгаварт зардлын шинжилгээ, төсөвлөлт тодорхой бус байдалд шийдвэр гаргах арга зүй, сүлжээ төлөвлөлтийн аргууд болон хөрөнгө оруулалтын төслийн үр ашгийг шинжлэх арга зүйн асуудлыг онол, арга зүйн хувьд дэлгэрэнгүй авч үзсэн.

Хувь хүний орлогын албан татвар




Сувдаа Д.

Хувь хүний орлогын албан татвар / Ред. Д. Дуламсүрэн. –УБ.: “Тод бичиг” ХХК, 2016. -152х.

Сүүлийн жилүүдэд Монгол улсын эдийн засаг нилээд өндөр хурдацтай хөгжиж, ялангуяа байгалийн баялгаа эрчимтэй эргэлтэд оруулах болсон нь нийгэм-эдийн засгийн олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг бий болгож байгаа боловч үүнийг дагалдаад сөрөг хандлага ч гарах болсон нь татвар ногдуулалтын асуудлыг боловсруулахад хүртэл нөлөөлж байна. Энэ бүхнийг иш үндэс болгож ХХОАТ ногдуулалт сэдвийг сонгож судалгааны онол арга зүйн чиг баримжаа, хүрээ, чиглэлийг тодорхойлсон болно.

Даатгалын эдийн засаг ба нийгмийн даатгалын тогтолцоо




Дагвадорж Ч.

Даатгалын эдийн засгийн ба нийгмийн даатгалын тогтолцоо / Ред. Н.Тунгалаг. –УБ.: “Ундарга принт” ХХК, 2012. -198х.

Монголын нийгмийн даатгалын тогтолцооны үүсэл, хөгжил, нийгмийн даатгалын үндсэн үзүүлэлтүүд, даатгалын төрөл тус бүрийн өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудлууд, өөрчлөлт, шинэчлэлт, хандлага зэргийг багтаасан.

Өндөр бүтээмжтэй оюутны 7 дадал



Өндөр бүтээмжтэй оюутны 7 дадал /Ред. Д. Гэрэлмаа. –УБ.: 2014.-309х.

АНУ-ын нөлөө бүхий 25 эрхмийн нэгээр шалгарсан багш, зөвлөх Стефен Р.Ковигийн 40 сая хувь борлогдсон, дэлхийд алдартай “Үр бүтээлтэй хүмүүсийн 7 дадал” ном дээр тулгуурлан бичигдсэн тус номыг амжилтанд тэмүүлэгч монголын мянга мянган оюутан залууст зориулж байна.

Боловсрол судлалын ном зүй



Батсайхан Б., Дэлгэржав М.

Боловсрол судлалын ном зүй. /Ред. Ш.Шагдар.-УБ.: “Соёмбо принтинг” ХХК, 2016. - 633х.

Боловсрол судлалын чиглэлээр судалгааны бүтээл гаргасан зохиогчдын ном зүйг багтаасан.

Эрдэм шинжилгээний бичиг



Эрдэм шинжилгээний бичиг. /Ред. Б.Дэмид. –УБ.: “МУИС пресс “ хэвлэлийн газар, 2016. -199х.

МУИС-ийн Завхан сургуулийн багш, оюутнуудын эрдэм шинжилгээний илтгэл, бүс, улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэл, олон улсын эрдэм шинжилгээний илтгэлүүдийг багтаасан.

Номын санч- мэдээллийн ажилтны ширээнд



Номын сан-мэдээллийн ажилтны ширээнд. /Ред. Д.Энхтунгалаг. –УБ.: “Соёмбо принтинг” ХХК, 2015. -112х.

Номын сан-мэдээллийн ажилтны нэг үүрэг нь шинэ мэдээ мэдээллийг хэн бүхнээс урьтан олж, уншигч хэрэглэгчдэд хүргэх явдал билээ. Үүний тулд номын сангийн фонд, каталог, лавлагаа номзүйн аппаратыг зохих дүрэм журам, онолын үндсэн дээр зохион байгуулж, уншлага үйлчилгээний ажлыг явуулахад мэргэжилтэн бүрийн заавал мэдэх гол гол сэдэвүүдийг багтаасан.

Хүнсний нэрийн гурван хэлний толь бичиг




Онгоодой Ч.

Хүнсний нэрийн гурван хэлний толь бичиг. –УБ.: 2005. -172х.

Энэхүү хүнсний нэрийн гурван хэлний дүймэн нь хүнс судлалын мэргэлжилтэн хийгээд энэ шинжлэх ухаанд шамдан суралцагч, их дээд сургуулийн оюутан суралцагчдад зориулав.

Сонгодог 100 зохиолч



Даниел С.Бөрт.

Сонгодог 100 зохиолч. –УБ.: 2016. -745х.

Зохиолчдыг зохиол бүтээлээр нь бус, харин үзэл бодлын нөлөөлөл, гүн ухааны цар хүрээгээр үнэлж эл номонд багтаасан.


Олон улсын эдийн засгийн харилцаа



Тунгалаг Д. , Эрдэнэчулуун . Олон улсын эдийн засгийн харилцаа. –УБ.: 2015. -223х.

Энэхүү бүтээлд олон улсын эдийн засгийн харилцааны агуулга, хэлбэр, олон улсын худалдаа, капиталын шилжилт хөдөлгөөн, хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөн, олон улсын валютын харилцаа, улс үндэстэн дамнасан корпораци, олон улсын интеграцлагдсан нэгдэл холбоо, олон улсын эдийн засгийн байгууллага, эдийн засгийн чөлөөт бүс, шинээр аж үйлдвэржсэн орнууд, нэг хүнд ногдох орлогын түвшин дунд, дундаас доогуур орнууд, дэлхийн эдийн засаг ба Монгол улсын эдийн засгийн талаар өгүүлсэн.

SPSS шинжилгээ үр дүн тайлбар



Чимгээ Д., ба бус

SPSS шинжилгээ үр дүн тайлбар. –УБ.: 2015. -291х.

Энэхүү номонд SPSS дээр хийсэн статистикийн үр дүнгийн тайлбарт илүү анхаарал хандуулсан. Мөн магадлал, статистик шалгууруудын талаарх ойлголт түүний үр дүнгийн талаар оруулсан.

Бизнесийн мэдээллийн систем онол ба хэрэглээ



Оюунбилэг П., ба бус

Бизнесийн мэдээллийн систем онол ба хэрэглээ. /Ред. О.Төлеу. –УБ.: 2016. –330х.

Бизнесийн мэдээллийн систем онол ба хэрэглээ номонд өнөө үед чухлаар тавигдаж байгаа бизнес өгөгдлийг боловсруулах, шинжлэх, улмаар шийдвэр гаргахад ашиглах систем, програм хэрэгслийн талаар нилээд дэлгэрэнгүй онолын үндэслэл болон практик хэрэглээ талаас авч үзсэн.

Бизнесийн мэдээллийн систем онол ба хэрэглээ



Оюунбилэг П., ба бус

Бизнесийн мэдээллийн систем онол ба хэрэглээ. /Ред. О.Төлеу. –УБ.: 2016. –432х.

Бизнесийн мэдээллийн систем онол ба хэрэглээ номонд өнөө үед чухлаар тавигдаж байгаа бизнес өгөгдлийг боловсруулах, шинжлэх, улмаар шийдвэр гаргахад ашиглах систем, програм хэрэгслийн талаар нилээд дэлгэрэнгүй онолын үндэслэл болон практик хэрэглээ талаас авч үзсэн.

Номын сангийн хууль тогтоомжийн эмхэтгэл



Номын сангийн хууль тогтоомжийн эмхэтгэл. /Ред. Э.Туяа. –УБ.: 2016. –174х.

Номын сангийн хууль, дүрэм журмыг багтаасан.

Монгол улсын статистикийн эмхэтгэл-2015



Монгол улсын статистикийн эмхэтгэл -2015. –УБ.: 2016. -413х.

2012-2015 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг багтаасан.
Номын сангийн хууль, дүрэм журмыг багтаасан.